

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: АГГ-2022/16-ШТА-ГА

Барилга байгууламжийн зураг, төсөвт хийх магадлалын чанарыг
сайжруулах шаардлагатай байна

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Ю.Энхтуяа

Утас: 70533552 Цахим хаяг: Enkhtuyayu@audit.gov.mn

Аудитор Ч.Наранбадрах

Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор С. Цэрэнбаяр Аудитын менежер: Т.Хонгорзул Аудитор: Ю. Энхтуяа Ч.Наранбадрах 2022 оны 4 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу. Тайланг www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү. Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот	Товчилсон үгийн тайлбар	2
	Хүснэгт, график, зургийн жагсаалт	2-3
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	4-5
	Ерөнхий мэдээлэл	5-7
	Бүлэг А. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажлын чанарыг сайжруулах шаардлагатай байна	8-11
	1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.	11-20
	2. Гүйцэтгэлийн алдаатай зураг, төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.	
	3.Төсөл, арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэж, үр ашигтай төлөвлөх шаардлагатай байна.	
	Бүлэг Б. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц удаашралтай байна	
	1.Худалдан авах ажиллагааг зарлах, үнэлэх, гэрээ байгуулах үйл ажиллагааг түргэн шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.	
	2.Захиалагчийн талаас гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулж байгаа үйл ажиллагаа үр дүнгүй байна.	
	3.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц болон ашиглалтын байдалд дотоод хяналтыг гүйцэтгэх шаардлагатай байна.	
	4.Тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, хөрөнгө оруулалт үр дүнгүй байна.	
	Дүгнэлт	21
	Зөвлөмж	22
	Тэргүүлэх аудиторын тушаал	23

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОГ	Байгаль орчны газар
БНбД	Барилгын норм ба дүрэм
ТЭЗҮ,	Техник, эдийн засгийн үндэслэл
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МАА	Мал аж ахуй
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгт 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн ТАХ-ий жагсаалт
Хүснэгт 2	Эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ий жагсаалт
Хүснэгт 3	Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан болон баригдаж байгаа ЕБС-ын хүчин чадал, суралцагчдын тооны харьцаа
Хүснэгт-4	Сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын багцын мэдээлэл
Хүснэгт 5	ХАА-г зохион байгуулсан хугацааны судалгаа
Хүснэгт 6	Дуусаагүй барилгын жагсаалт
График 1	ТЕЗ-аас Сангийн яаманд хүргүүлсэн санал ба батлагдсан байдал
График 2	ТАХ-ий хуваарилалт
График 3	ХАА-г зарласан цаг хугацааны харьцуулалт

Зургийн жагсаалт

Зураг 1	Номгон сумын 320 хүүхдийн сургуулийн эскиз ба бодит байдал
Зураг 2	Рентгенээр тоноглогдсон автобусны байдал
Зураг 3	Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын байдал
Зураг 4	Цогт-Овоо 320 хүүхдийн сумын сургууль
Зураг 5	Номгон сумын ЭМТ-ийн барилга
Зураг 6	Манлай сумын ЭМТ-ийн барилга
Зураг 7,8	Баян-Овоо сумын орон сууц
Зураг 9	Гүйцэтгэл баталгаажуулсан байдал
Зураг 10,11	Ашиглаагүй байгаа тоног төхөөрөмж
Зураг 12,13	ХАА-н тоног төхөөрөмжийн хадгалалтын байдал
Зураг 14,15	Малын тэжээлийн тоног төхөөрөмж
Зураг 16-19	Малын түүхий эдийн лабораторийн багаж, тоног төхөөрөмж
Зураг 20,21	Сургуулийн спорт заал
Зураг 22-26	Булган сумын цэцэрлэгийн барилгын байдал

Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.6-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан аудитын сэдвийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газарт хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд: • Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх, • Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт, үр дүнтэй байгаа эсэх,
Хамрах хүрээ:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээний төлөвлөлт хийсэн судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайланд үндэслэн аудитыг гүйцэтгэлээ. Тус аудитаар улсын төсвийн хөрөнгө оруулалттай төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд оролц Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллагууд, сумдын Засаг дарга нар, төсөл арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, бусад байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУС 3000-3100, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ыг баримтлан холбогдох баримт материалд үндэслэж, тулган баталгаажуулах, албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, нөхцөл байдлын шинжилгээ хийх, хөрөнгө оруулалтыг бодит байдалд очиж зураг авалт хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудсын дагуу аудитын дүн, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулав.
Хүндрэл, бэрхшээл	Аудит гүйцэтгэх хугацаа шахуу, нийт хөрөнгө оруулалтыг газар дээр нь очиж, хүрч ажиллах хүний нөөц дутагдалтай байлаа.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор С.Цэрэнбаяр хянан удирдаж, аудитын менежер Т. Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, аудитор Ю.Энхтуяа, Ч.Наранбадрах, Т.Бүрнээбаяр нар хэрэгжүүлэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Өмнөговь аймагт он дамжин хэрэгжиж буй 9, шинээр 10 нийт 33,716.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 19 төсөл арга хэмжээг улсын төсвийн 13,514.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

График-1 ТЭЗ-аас Сангийн яаманд хүргүүлсэн санал ба баталсан байдал



Хүснэгт-1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн ТАХ-ий жагсаалт

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гүйцэтгэгч
		Эхлэх	Дуусах			
III.1.3.3	Спорт цогцолборын тоног төхөөрөмж /Өмнөговь, Даланзадгад сум/	2021	2021	195.0	195.0	Цамхаг өргөө ХХК
IV.2.1.1	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2018	2021	3,153.5	607.3	Говийн өгөөж ХХК
XII.1.96	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	2021	2021	529.0	529.0	Гээт ХХК
XIII.1.1.13	Багшийн хөгжлийн төвийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	2019	2021	5,443.2	1,000.0	Хүннүгийн говь ХХК
XIII.1.1.47	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Номгон сум/	2018	2022	4,748.0	1,115.0	Өгөөмөр баян дэнж ХХК
XIII.1.1.69	Сургуулийн барилга, 960 суудал /Өмнөговь, Цогтцэций сум/	2019	2021	6,713.6	4,213.6	Грийн ресурс констракшн ХХК
XIII.1.1.115	Сургуулийн спорт заалны барилга /Өмнөговь, Булган сум/	2019	2021	1,598.5	300.0	Шинэ соёл констракшн ХХК

XIII.1.1.134	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/	2020	2021	1,155.0	455.0	Өгөөмөр мон тех ХХК
XIII.1.2.37	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Цогт-Овоо сум/	2021	2021	137.0	137.0	Аз билэгтэй ХХК
XIII.1.2.38	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Булган сум/	2021	2021	99.0	99.0	Нагури констракшн ХХК
XIII.1.3.15	Сургуулийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Ноён, Сэврэй, Цогтцэций сум/	2021	2021	300.0	300.0	Чиглэл ХХК, Ногун ХХК, Компассаплай ХХК, Эзэнговийн элс ХХК
XIV.1.35	Соёлын төвийн барилга, 280 суудал /Өмнөговь, Баяндалай сум/	2019	2021	2,320.7	300.0	Эртний говь ХХК
XVII.1.9	Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /Өмнөговь, Булган сум/	2020	2022	1,900.0	650.0	Бэст агро интэрнэйшнл ХХК
XIX.1.12	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Номгон сум/	2020	2021	1,527.8	1,027.8	Тэлмүүн доной ХХК
XVII.3.7	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын сум дундын лабораторийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Баяндалай, Ноён, Ханхонгор, Хүрмэн сум/	2021	2021	240.0	240.0	Синапс ХХК
XIX.1.24	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Манлай сум/	2020	2021	1,517.0	1,017.0	Бизнес фокус ХХК
XIX.1.48	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Сэврэй сум/	2021	2022	1,650.0	600.0	Гүйцэтгэгч шалгараагүй
XIX.3.18	Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн автомашин /Өмнөговь, Баяндалай, Булган, Баян-Овоо, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Ханбогд, Хүрмэн, Сэврэй, Цогт-Овоо сум/	2021	2021	429.0	429.0	Уаз мега ХХК
XIX.3.19	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн рентген аппаратаар тоноглогдсон эмнэлгийн автомашин /Өмнөговь, Даланзадгад сум/	2021	2021	300.0	300.0	Сүвэн уул ХХК
НИЙТ				33,716.3	13,514.7	

Нийт санхүүжилтийн 83 хувийг барилга, байгууламж, 10 хувийг тоног төхөөрөмж, 5 хувийг автомашин, 2 хувийг барилгын их засварын ажилд зарцуулахаар хуваарилсан байна.

График-2 ТАХ-ий хуваарилалт



Тайлант онд 4,455.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 ТАХ Өмнөговь аймагт эрх шилжин хэрэгжсэн байна.

Хүснэгт-2 Эрх шилжин хэрэгжсэн ТАХ-ий жагсаалт

Д/д	Шинэ/Шилжих	ТТ/ББ/ТЭЗҮ/ИЗ	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Шинэ	Тоног төхөөрөмж	Спорт цогцолборын тоног төхөөрөмж /Өмнөговь, Даланзадгад сум/	2021	2021	195.0	195.0
2	Шинэ	Их засвар	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Цогт-Овоо сум/	2021	2021	137.0	137.0
3	Шинэ	Их засвар	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Булган сум/	2021	2021	99.0	99.0
4	Шинэ	Тоног төхөөрөмж	Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын сум дундын лабораторийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Баяндалай, Ноён, Ханхонгор, Хүрмэн сум/	2021	2021	240.0	240.0
5	Шинэ	Тоног төхөөрөмж	Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн автомашин /Өмнөговь, Баяндалай, Булган, Баян-Овоо, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Ханбогд, Хүрмэн, Сэврэй, Цогт-Овоо сум/	2021	2021	429.0	429.0
6	Шинэ	Тоног төхөөрөмж	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн рентген аппаратаар тоноглогдсон эмнэлгийн автомашин /Өмнөговь, Даланзадгад сум/	2021	2021	300.0	300.0
7	Шилжих	Барилга байгууламж	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/	2020	2021	1,155.0	455.0
8	Шилжих	Барилга байгууламж	Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /Өмнөговь, Булган сум/	2020	2022	1,900.0	650.0
Нийт дүн						4,455.0	2,505.0

А. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх ажлын чанарыг сайжруулах шаардлагатай байна

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна

1.1. Жагсаалтаар баталсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцэж байна.

1.2. Аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 30-ы өдрийн 1-1182 дугаар албан бичгийн хавсралтаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал”-ыг батлан хүргүүлсэн ба батлагдсан төсөл, арга хэмжээ нь салбарын бодлого, ТЕЗ-ийн саналд үндэслэгдсэн байна.

1.3. Нийт 174,713.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2021 онд 113,626.8 сая төгрөгөөр санхүүжих 46 төсөл, арга хэмжээний санал хүргүүлсэн ба Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам, болон холбогдох аргачлал”-ын дагуу үнэлж, эрэмбэлсэн байна.

2. Гүйцэтгэлийн алдаатай зураг төслийг магадлалаар баталгаажуулсан байна

2.1. Барилга байгууламжийн зураг төсөл зохиох ажлын даалгаврыг боловсруулахдаа аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн үндсэн чиглэлд үндэслэн БНБД-ийн дагуу боловсруулсан байна.

2.2. Барилга байгууламжийн зураг төсвийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүд гүйцэтгэсэн байна.

2.3. Барилга байгууламжийн зураг төсөлд олгосон зардал нь зураг төсвийн жишиг үнийг үндэслэсэн байна.

2.4. Булган, Цогт-Овоо сумдын цэцэрлэгийн барилгын их засварын ажлын төсвийг МХГ-ын Барилгын техник хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн, мэргэшсэн төсөвчид гүйцэтгэсэн ба засварын ажлын зураг хийгээгүй байна.

2.5. Барилга байгууламжийн засварын ажлын төсвийг зохиохын өмнө тухайн барилгад хөрөнгө оруулагч, захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөл, зураг төслийн инженерүүд оролцон биет хэмжилт хийж баталгаажуулах, дээрх үзлэг, хэмжилтийг үндэслэн засварын ажлын зургийг гүйцэтгэсний дараа төсвийг зохиох шаардлагатай байна.

2.6. Номгон сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын зургийн зохиогч “Говь гурван зам” ХХК нь барилгын төсөвт өртгийг тооцохдоо 1899 м2 талбайг орхигдуулж тооцсон ба БХТ-ийн

2017 оны 10 дугаар сарын 12-ы өдрийн 737/2017 дугаартай магадлалын дүгнэлтээр 3,332.9 сая төгрөгөөр баталгаажуулж, дээрх дүнгээр улсын төсөвт суулгасан байна.

2.7. Барилгын төсвийг алдаатай гүйцэтгэж, баталгаажуулснаас, төсвийг дахин хийж, магадлалаар оруулах, нэмэлт гэрээ байгуулах зэрэг ажлууд гарч, цаг хугацааны болон бусад хүндрэл үүссэн байна.

2.8. Тус барилгын төсвийг дахин хянуулж, БХТ-ийн 2018 оны 9 дүгээр сарын 19-ы өдрийн 1259/2018 дугаартай магадлалын дүгнэлтээр 4,515.0 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

2.9. Мөн барилгын эх загвар зурагт гадна ханыг өнгөлгөөний тоосгоор өрөхөөр зурагдсан боловч хийцлэлийн зураг, төсөвт тусгаагүй ба байгаль, цаг уурын нөхцөлийг харгалзан барилгын ажлын явцад 232.3 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулан гадна ханыг өнгөлгөөний тоосгоор өнгөлсөн байна.

Зураг 1 Номгон сумын 32 хүүхдийн сургуулийн барилгын эскиз ба бодит байдал



2.10. Багшийн хөгжлийн төвийн барилгын халаалт, агаар сэлгэлтийн ажлын зургийг "Шигота" ХХК гүйцэтгэхдээ барилгын дам нурууг тооцоогүйгээс агааржуулагчийн систем хэт дор байрлаж, дотор зохион байгуулалттай нийцэхгүй байсан тул салхивчийн ажлыг гүйцэтгэлийн явцад бүрэн өөрчилсөн байна.

2.11. Мөн 5 давхар барилгыг лифтгүй төлөвлөсөн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний налуу шатыг БНБД-ийн дагуу төлөвлөөгүй, ариун цэврийн өрөөний тоноглол, дулааны тоолуур орхигдуулсан зэрэг зураг төсөлтэй холбоотой зөрчлүүд гарсан байна.

2.12. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилгын зураг төсөв нь 2011 онд Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын захиалгаар хийгдэж батлагдсан ба барилгын ажлыг 2018 онд эхэлсэн байна.

2.13. Дээрх барилгын ажлыг эхлэх үед газрын байршил өөрчлөгдсөнөөс шалтгаалан суурийн холболтын зураг, төсвийг шинээр хийж, хийцлэлд өөрчлөлт орсноор барилга угсралтын ажилд 593.8 сая төгрөг, гадна инженерийн шугам сүлжээний ажилд 113.5 сая төгрөг нийт 707.3 сая төгрөгийн нэмэлт төсөв зарцуулсан байна.

3.Төсөл, арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэн, үр ашигтай төлөвлөх шаардлагатай байна

3.1. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан болон баригдаж байгаа сургуулийн хүчин чадлыг боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалын дагуу тооцсон суралцагчдын тоотой харьцуулсан судалгаанаас үзэхэд зарим сумдад сургуулийн суудлыг сурагчдын тооноос хэт давсан байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт-3 Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан болон баригдаж байгаа ЕБС-ын хүчин чадал, суралцагчдын тооны харьцаа

№	Сумын нэр	Сурагчдын тоо				Хуучин сургуулийн хүчин чадал	Шинэ сургуулийн хүчин чадал	Хуучин барилгыг ашиглаж байдал
		2017	2018	2019	2020			
1	Баян-Овоо	206	213	223	230	320	320	Сургуулийн өргөтгөлөөр ашиглаж байгаа
2	Номгон	247	237	245	249	320	320	сургуулийн бус зориулалтаар ашиглаж байна.
3	Сэврэй	178	207	204	213	320	320	ашиглалтын шаардлага хангахгүй буулгасан.
4	Хүрмэн	112	121	122	140	320	320	орон сууцны зориулалтаар тохижуулсан
5	Цогт-Овоо	245	245	255	271	240	320	орон сууцны зориулалтаар тохижуулсан

3.2. “Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний явуулын барилга, тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлын ТЭЗҮ боловсруулагдсан боловч нийлүүлэгдсэн 21 нэр төрлийн тоног төхөөрөмжөөс нийт 412.8 сая төгрөгийн үнэ бүхий малын тэжээл холигч, МАА-н зориулалтаар ашиглах тэжээлийн эрдэс, амин дэм, ферментацийн төхөөрөмж, малын тэжээл тараагч гэсэн 3 тоног төхөөрөмж нь Булган суманд малын тэжээл тариалдаггүй учир ашиглагдахгүй байна.

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулсан барилга байгууламж, их засварын ажил нь зураг төсөл нь баталгаажсан буюу төсөвлөлтийн шаардлага хангасан байна.

3.4. Зарим төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжих боломжгүй байна. Тухайлбал:

- Улс, орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтыг батлахдаа Цогтцэций, Манлай, Баян-овоо суманд 1,949.2 сая төсөвт өртөг бүхий 42 айлын орон сууцыг барихаар баталсан ба 2020 онд санхүүжих 432.0 сая төгрөг, 2021 онд үлдэгдэл 1,512.7 сая төгрөгийг олгоно гэж түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зарласан боловч өнөөдрийн байдлаар зөвхөн Баян-Овоо сумын 7 айлын орон сууц баригдаж байна,
- Булган сумын сургуулийн спорт заалны барилгын гүйцэтгэгчээр "Шинэ соёл констракшн" ХХК нь 2019 оны 7 дугаар сард 1,598.5 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан боловч Сангийн яамнаас тавьсан шаардлагын дагуу “гэрээний нийт үнийн дүн 1,000.0 сая төгрөг

байна” гэж гэрээ байгуулсан боловч 2020 оны 7 сард “гэрээний нийт үнийн дүн 1,598.5 сая” болгон шинэчилсэн,

- Баяндалай сумын Соёлын төвийн барилгыг “Эртний говь” ХХК нь 2019 оны 6 дугаар сард 2,179.1 сая төгрөгөөр гүйцэтгэхээр шалгарсан боловч Сангийн яамны шаардлагын дагуу “гэрээний нийт үнийн дүн 1,800.0 сая төгрөг” гэж гэрээ байгуулсан боловч 2020 оны 4 сард гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж “нийт үнийн дүн 2,179.5 сая төгрөг” болгосон байна.

3.5. Гэрээний үнийн дүн шинэчилсэн хоёр тохиолдол “Сангийн яамны шаардлагаар” гэх тайлбартай байгаа нь он дамжин хэрэгжих барилга байгууламжид ашиглах жишиг гэрээ байх шаардлагатайг харуулж байна. Мөн гэрээний ойлгомжгүй байдлаас болж олон дахин гэрээ шинэчилж гүйцэтгэчийг чирэгдүүлэх, санхүүжилт удаашрах нөхцөл үүссэн байна.

3.6. Улсын төсөвт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Б. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх үйл явц удаашралтай байна

1. Худалдан авах ажиллагааг зарлах, оролцогчдыг үнэлэх, гэрээ байгуулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.

1.1 ТАХ-г тухайн онд хэрэгжих боломжтой хугацаанд эрх шилжүүлсэн боловч худалдан авах ажиллагааг эрх шилжүүлснээс хойш дунджаар 72 хоногийн дараа зарласан байна.

График-3 ХАА-г зарласан цаг хугацааны харьцуулалт



1.2. ТАХ-ий гэрээг 6-8 саруудад байгуулсан байгаа нь тайлант онд хэрэгжихэд хүндрэл үүсгэх эрсдэлийг дагуулж байгаад анхаарч ажиллах тухай зөвлөмжийг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлээ.

1.3. Сургуулийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Ноён, Сэврэй, Цогтцэций сум/ 300 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 4 багц болгон хувааж, 2021 оны 5 дугаар сараас хойш 4 удаа зарласан байна.

1.4. Дээрх ажлуудаас 4-р багцад “Эзэн говийн элс” ХХК 2021 оны 12 дугаар сард шалгарч, 2022 оны 2 дугаар сард тоног төхөөрөмжийг хүлээлгэж өгсөн байна. Ногун ХХК 2-р багцын 82.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ирүүлээгүй байна.

Хүснэгт 4 Сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын багцын мэдээлэл

	БАГЦ ТЕНДЕРИЙН НЭР	ТӨСӨВТ ӨРТӨГ	ШАЛГАРСАН ГҮЙЦЭТГЭГЧ
1	Гал тогооны тоног төхөөрөмж	69,353,000	Чиглэл ХХК
2	Сургуулийн ширээ сандал	82,265,000	Ногун ХХК
3	Сургуулийн тоног төхөөрөмж	93,307,000	Компаскай ХХК
4	Монгол улсад үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн	55,075,000	Эзэнговийн элс ХХК

Хүснэгт 5 ХАА-г зохион байгуулсан хугацааны судалгаа

№	Ажлын нэр	Эрх шилжиж ирсэн огноо	ХАА-ы төлөвлөгөө- гөөр батлагдсан огно	Үнэлгээний хороо байгуулсан	ХАА зарласан огноо	Эрх шилжиж ирснээс хойш зарлах хүртэл хоног
1	Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарын сум дундын лабораторийн тоног төхөөрөмж /Өмнөговь Баяндалай, Ноён, Ханхонгор, Хүрмэн сум	2021.02.10	2021.3.26	2021.4.16	2021.4.27	76
2	Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн автомашин /Өмнөговь, Баяндалай, Булган, Баян-Овоо, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Ханбогд, Хүрмэн, Сэврэй, Цогт-Овоо сум	2021.02.25	2021.3.15	2021.4.20	2021.05.01	65
3	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Цогт-Овоо сум	2021.02.24	2021.3.12	2021.04.20	2021.04.21	56
4	Цэцэрлэгийн барилгын их засвар /Өмнөговь, Булган сум	2021.02.24	2021.3.24	2021.04.19	2021.04.21	56
5	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн рентген аппаратаар тоноглогдсон эмнэлгийн автомашин	2021.02.24	2021.02.15	2021.4.19	2021.6.07	97
6	Цөлжилт газрын доройтолд орсон газарт хамгаалалтын ойн зурвас байгуулах	2021.01.29		2021.4.14	2021.4.20	81


Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1.5. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нийлүүлэх явуулын үйлчилгээтэй рентген аппаратаар тоноглогдсон автомашины техникийн үзүүлэлтийг АЗДТГ-ын дарга 2021 оны 5 дугаар сарын 19-ны өдөр батлахдаа үйлдвэрлэсэн оныг “2020 оноос хойш” гэсэн боловч 2021 оны 8 дугаар сарын 02-ны өдөр “Сүвэн уул” ХХК-тай гэрээ байгуулахдаа “2014 оноос хойш” гэж өөрчилсөн,

1.6. Тус автомашин нь 2015 онд БНСУ-д үйлдвэрлэгдсэн, 287 838 км явсан, 2021 оны 3 сард импортлогдсон, 25 хүний суудалтай Хьюндай маркийн автобусыг доторлож, рентген

аппарат суурилуулсан байна. Талбарт ажиллах үеийн байдлаар 4 амортизатор ажиллагаагүй байсныг сольж байсан ба доод эд анги зэвэрсэн байв.

Зураг 2 Рентгенээр тоноглогдсон автобусны байдал



1.7. Эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэх түргэн тусламжийн автомашины техникийн үзүүлэлтийг боловсруулахдаа туулах чадварыг “УАЗ фургон автомашинтай дүйцэхүйц” гэсэн боловч бусад үзүүлэлтэд зөвхөн фургон автомашины үзүүлэлтийг тусгасан,

1.8. “Булган сумын сургуулийн спорт заалны барилга”-ын гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны нэг гишүүн ашиг сонирхлын мэдүүлэг бөглөөгүй, баримт материалд худалдан авах ажиллагааны гэрчилгээг хавсаргаагүй,

1.9. Мөн уг гишүүн нь барилгын захиалагчийн хяналтыг гүйцэтгэж, барилгыг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын нарийн бичгийн даргаар ажилласан ба тус барилгын ажлын туслан гүйцэтгэгчээр хамаарал бүхий компани нь ажилласан, ямар ажил гүйцэтгүүлсэн нь тодорхойгүй байна.

2. Захиалагчийн талаас гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулж байгаа үйл ажиллагаа үр дүнгүй байна.

2.1. Нийт төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээний хугацааг 1-3 удаа сунгаж, үндсэн гэрээнд өөрчлөлт оруулсан шалтгаан нь ковидын үеийн нөхцөл байдалтай холбоотой байна.

2.2. Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажлыг 2021 онд 4,213.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан боловч ажил хийгдээгүй, 2022 оны 8 дугаар сард хүлээлгэн өгөхөөр гэрээг сунгасан, 36 хувийн гүйцэтгэлтэй, 2022 оны ажил эхлээгүй байна.

Зураг 3 Цогтцэций сумын 960 хүүхдийн
сургуулийн барилга



Зураг 4 Цогт-Овоо сумын 320 хүүхдийн
сургуулийн барилга



2.3. Номгон сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга 80%-ийн гүйцэтгэлтэй, ковидын нөхцөл байдлаас шалтгаалан гэрээний хугацааг сунгасан байна.

Зураг 5 Номгон сумын ЭМТ-ийн барилга



Зураг 6 Манлай сумын ЭМТ-ийн барилга



2.4. Манлай сумын 15 ортой эрүүл мэндийн төв 63%-ийн гүйцэтгэлтэй, гадна ханын өрлөг БНБД, стандарттай нийцэхгүй байсан нь ГХБХБГ-ын инженерийн хяналтаар илэрсэн тул үүрэг даалгавар өгч, буулган дахин өрөх ажил хийгдэж байна.

2.5. Сэврэй сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын хөрөнгө оруулалтад 600.0 сая төгрөг батлагдсан боловч гүйцэтгэгч шалгараагүй, 2022 оны улсын төсөвт шилжүүлэн баталсан байна.

2.6. Цогт-Овоо сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд эхэлсэн ба 2021 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад 636.8 сая төгрөг батлан, нэмэлт гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэл 90%-тай үргэлжилж байна.

2.7. Баян-Овоо сумын төрийн албан хаагчдын орон сууцны ажил 90 хувийн гүйцэтгэлтэй барилгын ажил үргэлжилж байна.

Зураг 7,8 Баян-Овоо сумын орон сууц



2.8. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай барилга байгууламжийн ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэгчээр Барилгын хөгжлийн төв, ГХБХБГ, их засварын ажилд ГХБХБГ ажилласан байна.

2.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа 2019-2020 онуудад эхэлсэн нийт 14,306.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 барилга байгууламж 36-90 хувийн гүйцэтгэлтэй, дуусаагүй үргэлжилж байна.

Хүснэгт 6 Дуусаагүй барилгын жагсаалт

№	Байршил	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгчийн					Ажлын явц %	Нийт олгосон санхүүжилт
			Нэр	Гэрээний үнийн дүн	Ажил гүйцэтгэх		Гэрээний сунгалт		
					эхлэх	дуусах			
1	Баян-Овоо	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	ГЭЭТ ХХК	529.0	2020.06.22	2021.11.01	2022.04.01	90	476.1
2	Цогтцэций	Сургуулийн барилга, 960 суудал /Өмнөговь, Цогтцэций сум/	Грийн ресурс констракшн ХХК	6712.64	2019.09.09	2021.08.20	2022.08.20	36	2443.13
3	Номгон	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Номгон сум/	Тэлмүүн доной ХХК	1487.1	2020.05.15	2021.12.20		80	1178.3
4	Манлай	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Манлай сум/	Бизнес фокус ХХК	1445.4	2020.05.25	2021.12.31		63	911.0
5	Цогт-Овоо	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Цогт-Овоо сум/	Туст эр констракшн ХХК	4132.5	2019.07.20	2020.08.30	2022.07.29	90	3859.1
		НИЙТ ДҮН		14306.7					8867.6

2.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ, зураг төслийн ажил хийгдээгүй байна.

3. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц болон ашиглалтын байдалд дотоод хяналтыг гүйцэтгэх шаардлагатай байна.

3.1. Барилга байгууламжийн ажилд зохиогчийн хяналтын гэрээг байгуулж, гүйцэтгэл бүрд тайлан, ашиглалтад хүлээн авахад “Зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гаргаж баримт бичигт хавсаргасан байна.

3.2. Зураг төслийн чанар хангалтгүй, ашиглагчийн саналыг тусгаагүй байдлаас болж барилга угсралтын ажлын явцад гадна, дотор ханын өнгө, материал, дотор зохион байгуулалт, шалны бүтцийг өөрчлөх асуудал түгээмэл гарсан байна.

3.3. БХТ-ийн Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсээс “Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гарган баталгаажуулж, хавсаргасан байна.

3.4. Барилга угсралтын ажлын явцад зохиогч болон захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаас үүрэг даалгавар өгч, алдаа зөрчлийг арилгуулах талаар ажиллаж байгаа боловч барилга байгууламжийг хүлээн авах комисс ажиллахад алдаа дутагдлууд илэрч, үүрэг даалгаврууд өгөгдөж байгаа, барилга байгууламжийн зүгшрүүлэлтийн хугацаанд материал болон гүйцэтгэлийн чанараас шалтгаалсан доголдлууд гарч байгаа нь хяналт зохих үр дүнд хүрэхгүй байгааг харуулж байна.

3.5. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага болох БХТ, ГХБХБГ-ын холбогдох албан тушаалтнууд гүйцэтгэлийн санхүүжилт бүрийг баталгаажуулсан байна.

Зураг 9 Гүйцэтгэл баталгаажуулсан байдал

Батлав: Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга
Захиалагч
Эрүүл мэндийн яам

Барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэл №2
Барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэл №2

Гүйцэтгэгч
“Бизнес Фокус” ХХК

1. Барилга байгууламжийн нэр, байршил: “Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор” /Өмнөговь аймаг, Манлай сум/
2. Гэрээний дугаар: ЭМЯ/2020/01018
3. Гэрээний дүн: 1 445 414 243
4. Эзлэх ба дуусах хугацаа: 2020.05.25-2021.09.01
5. Гүйцэтгэл гаргасан хугацаа: 2020.12.16

№	Нийт төсөв /өртөөр/	Төсөвт өртөг	Ажил эхэлсэнээс хойшхи гүйцэтгэл		Урьд авсан санхүүжилт		Гайлцан үеийн гүйцэтгэл		Хянасан	Үлдэгдэл санхүүжилт	
			Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь		Дүн	Хувь
1	Ажиллах хүчин зардал	284,846,820	64,559,701	23%	48,823,742	17%	15,735,959	6%		220,287,119	77%
2	Материал	537,030,686	213,827,167	40%	153,468,211	29%	60,356,956	11%		323,212,519	60%
3	Газар	134,436,773	52,619,138	39%	21,959,449	16%	30,862,956	23%		81,817,635	61%
4	Машины ашиглалт	33,189,801	13,910,058	42%	11,056,544	33%	2,853,514	9%		19,275,743	58%
	Шууд зардалын дүн	989,509,079	344,916,064	35%	235,304,979	24%	109,811,085	11%		644,593,015	65%
5	Намгадвал зардал	101,723,731	33,055,367	32%	27,435,804	27%	5,619,583	6%		68,668,344	68%
6	Ашиг: 10%	163,684,922	64,189,717	39%	46,911,117	29%	17,294,500	11%		99,489,205	61%
	БУА-ын дүн	1,254,917,732	442,167,168	35%	309,651,000	25%	132,515,268	11%		812,750,564	65%
7	НӨАТ 10%	125,491,773	44,216,717	35%	30,965,190	25%	13,251,527	11%		81,275,056	65%
8	Нормчлолын сан	2,258,852	786,900	35%	597,373	25%	238,627	11%		1,462,952	65%
	Дүн	1,382,668,357	487,179,785	35%	341,174,463	25%	146,005,322	11%		895,488,572	65%
9	Захиалагчийн албаны зардал	25,098,355	8,546,810	34%	6,193,038	25%	2,353,772	9%		16,551,545	66%
10	Зургийн үнэ	0	0	0%	0	0%	0	0%		0	0%
11	Зохиогчийн хяналтын зардал	12,549,177	4,273,405	34%	3,086,519	25%	1,176,888	9%		8,275,772	66%
	Дүн	1,420,315,889	500,000,000	35%	350,454,020	25%	149,535,980	11%		920,315,889	65%
12	Магадлашгүй ажил	25,098,355	0	0%	0	0%	0	0%		25,098,355	100%
13	Бусад нэмэлт зардал	0	0	0%	0	0%	0	0%		0	0%
	Дүн	1,445,414,243	500,000,000	35%	350,454,020	24%	149,535,980	10%		945,414,243	65%

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
ЭМЯ-ны ЭЗСХ-ийн газрын дарга
ЭМЯ-ны ХОХ-ийн дарга
ЭМЯ-ны ЭХХ-ийн дарга
ЭМЯ-ны ЭЗСХ-ийн ерөнхий нягтлан бодогч
ЭМЯ-ны ХОХ-ийн мэргэжилтэн

БХТ-ийн захирал
БХТ-ийн СТХХ-ийн дарга
БХТ-ийн ББЗХХ-ийн дарга
БХТ-ийн ББЗХХ-ийн ахлах инженер
БХТ-ийн ББЗХХ-ийн хяналтын инженер
Өмнөговь аймгийн ГХБХБГ-ын дарга
Өмнөговь аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэн

Ц.Амарсанаа/
Г.Гантуул/
Г.Мансур/
С.Сүхтуяа/
О.Мянгарсүрэн/
О.Энхтуяа/
Б.Содномцэрэн/

“Бизнес Фокус” ХХК-ийн захирал
“Бизнес Фокус” ХХК-ийн инженер
Ц.Сэргэлэн/
Г.Бямбабаяр/

3.6. ТАХ-ий санхүүжилтийг баталгаажуулсан гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

3.7. ТАХ-ий гүйцэтгэлийн явц, хүлээн авсны дараах ашиглалтын байдалд захиалагчийн зүгээс дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.8. Зөрчил дутагдлыг зөвхөн аудитаар илрүүлэх бус захиалагчийн зүгээс дотоод хяналт шалгалтыг төсөл, арга хэмжээ бүрийн гүйцэтгэл, хэрэгжилт, ашиглалтын байдалд хийж алдаа зөрчлийг илрүүлэн, шуурхай арилгаж ажиллах шаардлагатай байна.

3.9. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийх дотоод хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Дотоод хяналт хэрэгжүүлэгч нь:

- үнэлгээний хороо,
- явцын хяналт,
- гэрээ байгуулах,
- хүлээж авах зэрэг гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа үйл ажиллагаанд оролцоогүй байж, илэрсэн алдаа дутагдлыг цаг алдалгүй арилгаж ажиллавал төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй байх боломжтой.

4. Зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, хөрөнгө оруулалт үр дүнгүй байна.

4.1. Биеийн тамир спортын улсын газартай байгуулсан БТСУХ/2021/3 тоот гэрээний дагуу “Цамхаг өргөө” ХХК-аас Биеийн тамир спортын газарт 94,959.6 сая төгрөгийн үнэ бүхий, 46 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна.

4.2. Дээрх тоног төхөөрөмжөөс 4.7 сая төгрөгийн саун, 2.5 сая төгрөгийн 2 ширхэг телевизорыг ашиглахгүй байна.

Зураг 10,11 Ашиглаагүй байгаа тоног төхөөрөмж



4.3. Булган суманд хэрэгжсэн 1,900.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий “Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний явуулын барилга, тоног төхөөрөмж”-өөс 1,098.3 сая төгрөгийн 21 нэр төрлийн тоног төхөөрөмж, машин механизмыг 2020 оны 12 сарын 14-ы өдөр “Бест агро интернэйшнл” ХХК нийлүүлсэн байна.

4.4. Тоног төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн боловч ашиглагч тодорхойгүй, бусад сумдад болон тариалагч иргэн, ААН-д хэрхэн ашиглуулах талаар шийдвэр гараагүй, гэрээ, дүрэм, журам байхгүй, тариф батлагдаагүй байна.

4.5. Талбарт ажиллах үеийн байдлаар дээрх тоног төхөөрөмж ил задгай, хувь иргэний хашаанд агуулсан, хадгалалт хамгаалалт хангалтгүй байлаа.

Зураг 12,13 ХАА-н тоног төхөөрөмжийн хадгалалтын байдал



4.6. Тоног төхөөрөмж Солонгос улсад үйлдвэрлэгдсэн, хүчин чадал сайтай боловч зарим техник нь технологийн хувьд зөрөөтэй байна. */Булган суманд нарийн мөрт технологиор тариалалтаа хийдэг ба өргөн мөртөөр тариалах зориулалттай байна./*

4.7. Дээрх техникүүдээс 235.9 сая төгрөгийн малын тэжээл холигч, 90.6 сая төгрөгийн МАА-н зориулалтаар ашиглах тэжээлийн эрдэс, амин дэм, ферментацийн төхөөрөмж, 86.2 сая төгрөгийн малын тэжээл тараагч нийт 412.8 сая төгрөгийн үнэ бүхий 3 тоног төхөөрөмж нь Булган суманд малын тэжээл тариалдаггүй учир ашиглагдахгүй байна.

Зураг 14,15 Малын тэжээлийн тоног төхөөрөмж



4.8. Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарын сум дундын лабораторийн тоног төхөөрөмж /Баяндалай, Булган, Баян-Овоо, Манлай, Мандал-Овоо, Номгон, Ханхонгор, Ханбогд, Хүрмэн, Сэврэй, Цогт-Овоо сум/ ажлын хүрээнд Булган суманд 58.5 сая төгрөгийн өртөгтэй, 39 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг “Синапс” ХХК нийлүүлсэн байна.

4.9. Дээрх багаж, тоног төхөөрөмжийг сумын ЗДТГ-ын эд хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн боловч ашиглагч тодорхойгүй, ашиглаагүй, ашиглах заавар орчуулгагүй байна.

4.10. Сумын ЗДТГ-аас лабораторийн өрөө тохижуулсан боловч дээврээс ус гоожсон, шороо тоос ихээр нэвтэрдэг, багаж, эд хөрөнгө тоосонд дарагдсан байгаа учир цаашид байрыг засварлах шаардлагатай байна.

Зураг 16-19 Малын түүхий эдийн лабораторийн багаж хэрэгсэл




4.11. Мөн Ханхонгор сумын мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмж зориулалтын өрөө тасалгаа байхгүйгээс ашиглаж эхлээгүй байна.

4.12. Булган сумын спорт заалны барилгын заалны хэсгийн халаалт муу, хаалга болон агааржуулагчаар их дулаан алддаг, дээврийн битүүмжлэл муу, шороо тоос ихээр нэвтэрдэг, салхитай үед дуу чимээ их байдаг байна.

4.13. Мөн гадна, дотор хананд шаврын хагарлууд үүссэн, 00-ын өрөөний дүүжин тааз эвдэрсэн, дээврээс цасны ус нэвтэрсэн, дотор цахилгаан, гэрэлтүүлэг зарим хэсэгт ажиллахгүй байна.

Зураг 20,21 Сургуулийн спорт заал



4.14. Булган сумын цэцэрлэгийн барилгын засварын ажлыг “Нагури констракшн” ХХК нь 92.3 сая төгрөгөөр гүйцэтгэсэн байна. Ажлыг 2021 оны 8 дугаар сарын 05-нд хүлээлгэн өгөх

гэрээтэй боловч 1 удаа сунгаж, 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комисс ажиллаж дүгнэлт гаргасан байна.

4.15. Гэвч улсын комиссын гишүүдээс өгөгдсөн үүрэг даалгавар биелэгдээгүй, халаалт авахад бүх радиатор хагарч, гоожсон учир усыг юүлсэн, одоог хүртэл засварлаагүй, ашиглагчид хүлээлгэж өгөөгүй байна.

Зураг 22-26 Булган сумын цэцэрлэгийн барилгын байдал



4.16. Дээрх доголдлоос шалтгаалан өвөл халаалт аваагүй, үйл ажиллагаа явуулж чадаагүй байхад Аймгийн ЗДТГ-аас 2021 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр гэрээг дүгнэж, 12 дугаар сарын 16-нд санхүүжилтийг олгосон байна.

Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөсөн байна.
2. Гүйцэтгэлийн алдаатай зураг, төсвийг магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.
3. Төсөл, арга хэмжээг тооцоо судалгаанд үндэслэж, үр ашигтай төлөвлөх шаардлагатай байна.
4. Худалдан авах ажиллагааг зарлах, үнэлэх, гэрээ байгуулах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах шаардлагатай байна.
5. Захиалагчийн талаас гэрээний хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулж байгаа үйл ажиллагаа үр дүнгүй байна.
6. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц болон ашиглалтын байдалд дотоод хяналтыг гүйцэтгэх шаардлагатай байна.
7. Зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй, хөрөнгө оруулалт үр дүнгүй байна.

Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Өмнөговь аймгийн Засаг даргад

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" дахь заалтыг хэрэгжүүлэн тоног төхөөрөмжийг үр ашигтай ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах,
- Он дамжин хэрэгжиж байгаа ТАХ-г ашиглалтад оруулах талаар холбогдох арга хэмжээ авах, төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтийн явцад дотоод хяналтыг зохион байгуулж, алдаа дутагдлыг цаг алдалгүй арилгах арга хэмжээг авч, хөрөнгө оруулалтын үр дүн, чанарыг сайжруулах,

Орон нутгийн өмчийн газарт

- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, тухайн ондоо хэрэгжих нөхцөлөөр хангаж ажиллах.

Дарга, Тэргүүлэх аудиторын тушаал



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 27 өдөр


Дугаар А/9

Даланзадгад

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 8 дугаар зүйлийн 8.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, Өмнөговь аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг аудитор (Ю.Энхтуяа)-д үүрэг болгосугай.


С.ЦЭРЭНБАЯР

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2022\А-09.Docx

016010046